



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠵᠠᠰᠭᠢᠶᠢᠨ ᠭᠠᠷ᠎ᠠ  
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠵᠠᠰᠭᠢᠶᠢᠨ ᠭᠠᠷ᠎ᠠ

# ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

## 2021 I-VII

## ГАРЧИГ

1. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ .....	1
1.1. Эрдэс бүтээгдэхүүний экспортын төсөөлөл, гүйцэтгэл.....	1
1.2. Төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл.....	1
1.3. Уул уурхай, олборлох салбарын төсөвт төвлөрүүлсэн орлого.....	2
2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР.....	4
2.1. Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл.....	4
2.1.1. Уул уурхай, олборлох салбар.....	4
2.1.2. Хүнд үйлдвэрийн салбар.....	4
2.1.3. Газрын тосны салбар .....	4
2.2. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл .....	6
2.3. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн .....	7
2.4. Аж үйлдвэрийн салбарт ажиллагсад.....	8
3. ГАДААД ХУДАЛДАА.....	9
3.1. Эрдэс бүтээгдэхүүний экспорт .....	9
3.1.1. Уул уурхай, олборлох салбар.....	9
3.1.2. Газрын тосны салбар .....	10
3.1.3. Хүнд үйлдвэрийн салбар.....	11
3.2. Эрдэс бүтээгдэхүүний импорт.....	11
3.2.1. Газрын тосны салбар .....	11

## 1. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ

### 1.1. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ТӨСӨӨЛӨЛ, ГҮЙЦЭТГЭЛ

Улсын Их Хурлын 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдөр баталсан МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТГ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИАР Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтүүдийг хүснэгтээр харуулав.

#### Эрдэс бүтээгдэхүүний экспортын төлөвлөгөө, гүйцэтгэл (биет хэмжээгээр)

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021		Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
			Төлөвлөгөө (Тодотгол)	I-VII		
1	Нүүрсний экспортын хэмжээг нэмэгдүүлэх	мян.тн	28,686.8	10,312.3	18,374.5	35.9%
2	Зэсийн баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх	мян.тн	1,118.4	747.5	370.9	66.8%
3	Төмрийн хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх	мян.тн	7,993.2	4,708.0	3,285.2	58.9%
4	Алтны олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх (МБ-нд тушаасан) <sup>1</sup>	тн	20.0	11.0	9.0	54.9%
5	Газрын тосны экспортын хэмжээг нэмэгдүүлэх	мян.бар	5,471.0	3,281.0	2,190.0	60.0%
6	Цайрын хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх <sup>2</sup>	мян.тн	119.2	75.2	44.0	63.1%
7	Хайлуур жоншны хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх <sup>3</sup>	мян.тн	714.0	458.2	255.8	64.2%

Эх сурвалж СЯ, ГЕГ, МБ

### 1.2. ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2021 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр 8,666.7 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 2,905.0 тэрбум төгрөг буюу 50.4 хувиар өссөн байна.

Үүнээс, эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 2,813.5 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 1,729.2 тэрбум төгрөг буюу 2.6 дахин өссөн байна. Төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээ, эзлэх хувийг салбараар харуулав.

- Уул уурхайн салбараас 2,648.7 тэрбум төгрөг буюу 30.6 хувь,
- Газрын тосны салбараас 124.8 тэрбум төгрөг буюу 1.4 хувь,
- Тусгай зөвшөөрлийн төлбөр 16.6 тэрбум төгрөг буюу 0.2 хувь,
- Бусад орлого 23.4 тэрбум төгрөг буюу 0.3 хувь.

Эрдэс баялгийн салбар нь Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 32.5 хувийг бүрдүүлж байна.

<sup>1</sup> Монголбанкны үнэт металл худалдан авалтын мэдээлэл болно.

<sup>2</sup> Цайр нь МУ-ын 2021 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад тусгагдаагүй заалт болно

<sup>3</sup> Хайлуур жонш нь МУ-ын 2021 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад тусгагдаагүй заалт болно.

### Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого, тэрбум төгрөгөөр

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл / I-VII /		Гүйцэтгэл	
		2020 (Тодотгол)	2021 (Тодотгол)	2020	2021	Өсөлт, бууралт	Хувь
Нийт дүн		2,857.3	4,795.9	1,084.3	2,813.5	1,729.2	2.6 <sup>1</sup>
УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАР							
Нийт дүн		2,698.1	4,530.5	1,027.2	2,648.7	1,621.5	2.6 <sup>1</sup>
1	Алт	212.6	183.8	85.4	125.5	40.1	47.0%
2	Зэс	1,127.7	2,684.2	522.4	1,779.2	1,256.8	3.4 <sup>1</sup>
3	Нүүрс	1,056.3	1,287.8	305.0	472.1	167.2	54.8%
4	Бусад	301.5	374.7	114.5	271.8	157.3	2.4 <sup>1</sup>
ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР							
5	Газрын тос	110.0	213.2	33.8	124.8	91.1	3.7 <sup>1</sup>
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БОЛОН БУСАД ОРЛОГО							
Нийт дүн		49.2	52.2	23.3	40.0	16.7	71.5%
6	Тусгай зөвшөөрлийн төлбөр	30.0	31.2	17.3	16.6	-0.6	-3.7%
7	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	6.6	2.5	4.0	0.6	-3.4	-85.6%
8	Төсөвт байгууллагын өөрийн орлого /СШ-ын орлого/	9.0	16.0	0.0	20.7	20.6	448.6 <sup>1</sup>
9	Бусад орлого	3.6	2.5	2.1	2.2	0.1	5.2%

Эх сурвалж: СЯ, АМГТТ

Тайлбар: 1 - дахин их

### 1.3. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАРЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГО

2021 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр улсын төсөвт 2,648.7 тэрбум төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Зэс 1,779.2 тэрбум төгрөг,
- Нүүрс 472.1 тэрбум төгрөг,
- Алт 125.5 тэрбум төгрөг,
- Төмөр 115.8 тэрбум төгрөг,
- Цайр 66.2 тэрбум төгрөг,
- Хайлуур жонш 61.2 тэрбум төгрөг,
- Бусад ашигт малтмал 28.6 тэрбум төгрөг.

Уул уурхай, олборлох салбараас улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 1,621.5 тэрбум төгрөг буюу 2.6 дахин өссөн байна.

Дараах ашигт малтмалын улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй гарсан байна. Үүнд:

➤ Зэс	1,256.8 (3.4 дахин) тэрбум төгрөг,
➤ Нүүрс	167.2 (54.8%) тэрбум төгрөг,
➤ Төмөр	73.2 (2.7 дахин) тэрбум төгрөг,
➤ Цайр	49.2 (3.9 дахин) тэрбум төгрөг,
➤ Хайлуур жонш	46.7 (4.2 дахин) тэрбум төгрөг,
➤ Алт	40.1 (47.0%) тэрбум төгрөг.

Харин дараах ашигт малтмалын улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй гарсан байна. Үүнд:

➤ Бусад	11.8 (29.1%) тэрбум төгрөг.
---------	-----------------------------

## 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

### 2.1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

#### 2.1.1. Уул уурхай, олборлох салбар

2021 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр 19,658.3 мян.тн нүүрс, 765.3 мян.тн зэсийн баяжмал, 9,994.8 кг алт, 3,783.5 тн молибдены баяжмал, 76.2 мян.тн хайлуур жоншны хүдэр, 32.0 мян.тн хайлуур жоншны баяжмал, 5,077.8 мян.тн төмрийн хүдэр, 2,304.1 мян.тн төмрийн хүдрийн баяжмал, 39.5 мян.тн цайрын баяжмал тус тус үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс 4,457.1 мян.тн буюу 29.3 хувь, зэсийн баяжмал 28.4 мян.тн буюу 3.9 хувь, молибдены баяжмал 356.4 тн буюу 10.4 хувь, хайлуур жоншны хүдэр 1.9 мян.тн буюу 2.5 хувь, төмрийн хүдэр 267.5 мян.тн буюу 5.6 хувиар тус тус өссөн байна.

Харин алт 457.5 кг буюу 4.4 хувь, төмрийн хүдрийн баяжмал 403.6 мян.тн буюу 14.9 хувь, хайлуур жоншны баяжмал 14.6 мян.тн буюу 31.4 хувь, цайрын баяжмал 1.8 мян.тн буюу 4.4 хувиар буурсан байна.

#### 2.1.2. Хүнд үйлдвэрийн салбар

2021 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр 2,508.9 мян.тн баяжуулсан нүүрс, 396.4 мян.тн нүүрсэн шахмал түлш, 5,843.1 тн катодын зэс, 19,766.0 тн металл бэлдэц, 18,819.5 тн металл цувимал, 2,237.1 тн ган төмөр хийц тус тус үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад баяжуулсан нүүрс 1,491.5 мян.тн буюу 2.5 дахин, нүүрсэн шахмал түлш 160.8 мян.тн буюу 68.3 хувь, катодын зэс 348.4 тн буюу 6.3 хувь, металл бэлдэц 8,346.9 тн буюу 73.1 хувь, металл цувимал 8,047.3 тн буюу 74.7 хувь хувиар тус тус өссөн байна.

Харин ган төмөр хийц 1,210.6 тн буюу 35.1 хувиар буурсан байна.

#### 2.1.3. Газрын тосны салбар

2021 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр 3,484.3 мян.бар газрын тос үйлдвэрлэсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2,103.9 мян.бар буюу 2.5 дахин өссөн байна.

### Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	2020		2021*		Өөрчлөлт			
			VII	I-VII	VII	I-VII	(5-3)=?, (5/3)=%	(6-4)=?, (6/4)=%	7	8
	1	2	3	4	5	6	7	8	9	10
<b>1. Уул уурхай, олборлолт</b>										
1.1	Нүүрс	мян.тн	2,314.6	15,201.2	1,053.4	19,658.3	-1,261.2	-54.5%	4,457.1	29.3%
1.2	Газрын тос	мян.бар	352.6	1,380.5	492.0	3,484.3	139.4	39.5%	2,103.9	2.5 <sup>1</sup>
1.3	Зэсийн баяжмал, м/агуулгаараа	мян.тн	110.0	736.9	103.7	765.3	-6.3	-5.7%	28.4	3.9%
1.4	Молибдены баяжмал, м/ агуулгаараа	тн	445.9	3,427.1	521.7	3,783.5	75.8	17.0%	356.4	10.4%
1.5	Цэвэршүүлээгүй алт	кг	2,601.8	10,452.3	2,075.2	9,994.8	-526.6	-20.2%	-457.5	-4.4%
1.6	<b>Төмрийн хүдэр, баяжмал:</b>									
	- Төмрийн хүдэр	мян.тн	964.3	4,810.3	824.7	5,077.8	-139.6	-14.5%	267.5	5.6%
	- Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	475.1	2,707.7	295.1	2,304.1	-179.9	-37.9%	-403.6	-14.9%
1.7	<b>Хайлуур жоншны хүдэр, баяжмал:</b>									
	- Хайлуур жоншны хүдэр	мян.тн	16.7	74.3	7.5	76.2	-9.2	-55.0%	1.9	2.5%
	- Хайлуур жоншны баяжмал	мян.тн	4.7	46.6	3.8	32.0	-1.0	-20.9%	-14.6	-31.4%
1.8	Цайрын баяжмал	мян.тн	6.4	41.3	4.6	39.5	-1.8	-27.4%	-1.8	-4.4%
<b>2. Боловсруулах үйлдвэр</b>										
<b>2.1. Хүнд үйлдвэр</b>										
2.1.1	Баяжуулсан нүүрс	мян.тн	222.3	1,017.4	114.9	2,508.9	-107.4	-48.3%	1,491.5	2.5 <sup>1</sup>
2.1.2	Нүүрсэн шахмал түлш	тн		235,564.0		396,385.7	0.0	0.0%	160,821.7	68.3%
2.1.3	Катодын зэс, 99%	тн	818.2	5,494.6	951.5	5,843.1	133.3	16.3%	348.4	6.3%
2.1.4	Металл бэлдэц	тн	196.3	11,419.1	4,536.7	19,766.0	4,340.4	23.1 <sup>1</sup>	8,346.9	73.1%
2.1.5	Металл цувимал	тн		10,772.2	5,167.5	18,819.5	5,167.5	100.0%	8,047.3	74.7%
2.1.6	Ган төмөр хийц	тн	29.3	3,447.6	2.2	2,237.1	-27.0	-92.3%	-1,210.6	-35.1%

Эх сурвалж: ҮСХ

Тайлбар: 1 - дахин их

## 2.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

тэрбум төгрөг

Салбар	2020		2021*		Өөрчлөлт			
	VII	I-VII	VII	I-VII	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	1,400.6	8,169.3	1,431.1	10,814.5	30.5	2.2%	2,645.3	32.4%
Уул уурхай, олборлолт	1,003.7	5,522.5	1,037.7	7,428.1	34.1	3.4%	1,905.6	34.5%
Нүүрс олборлолт	207.9	1,355.1	110.7	1,861.9	-97.2	-46.8%	506.8	37.4%
Газрын тос олборлолт	36.3	148.5	79.2	546.1	42.9	2.2 <sup>1</sup>	397.6	3.7 <sup>1</sup>
Металлын хүдэр олборлолт	719.6	3,775.5	817.9	4,835.5	98.4	13.7%	1,059.9	28.1%
Бусад ашигт малтмал олборлолт	23.8	126.8	24.0	152.1	0.1	0.5%	25.2	19.9%
Уул уурхайн туслах үйл ажиллагаа	16.1	116.6	5.9	32.6	-10.2	-63.2%	-84.0	-72.0%
Боловсруулах үйлдвэр	316.9	1,864.4	306.8	2,514.0	-10.1	-3.2%	649.6	34.8%
Үүнээс, хүнд үйлдвэр	98.4	516.4	74.5	726.8	-23.9	-24.3%	210.3	40.7%
Кокс болон газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	40.1	206.5		330.9	-40.1	-100.0%	124.5	60.3%
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8.2	44.4	3.9	60.1	-4.3	-52.3%	15.7	35.3%
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	32.0	128.7	40.3	168.0	8.2	25.6%	39.3	30.5%
Металл боловсруулах үйлдвэрлэл	17.5	132.3	29.4	162.6	12.0	68.4%	30.3	22.9%
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.2	2.2	0.6	3.5	0.3	2.4 <sup>1</sup>	1.2	54.7%
Тээврийн хэрэгслийн бусад тоног төхөөрөмж үйлдвэрлэл	0.3	2.3	0.3	1.7	-0.0	-0.8%	-0.6	-26.1%

Эх сурвалж: ҮСХ

Тайлбар: 1 – дахин их

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2021 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр 10.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.6 (32.4%) их наяд төгрөгөөр өссөн байна. Үүнд, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 7.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.9 (34.5%) их наяд төгрөгөөр өсөхөд нүүрс олборлолт 506.8 (37.4%) тэрбум төгрөг, металлын хүдэр олборлолт 1.0 (28.1%) их наяд төгрөг, газрын тос олборлолт 397.6 (3.7 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлөв.

Харин уул уурхайн туслах үйл ажиллагаа 84.0 (72.0%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд Уул уурхай, олборлох салбар 68.7 хувийг эзэлж байна.



## 2.3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН

тэрбум төгрөг

Салбар	2020		2021*			Өөрчлөлт	
	VII	I-VII	VII	I-VII	Гад-д	(4-2)=?, (4/2)=%	
1	2	3	4	5	6	7	8
Нийт дүн	1,718.9	9,184.2	2,091.0	14,073.6	9,082.8	4,889.3	53.2%
Уул уурхай, олборлолт	1,244.8	5,840.5	1,623.6	10,062.4	8,315.9	4,221.9	72.3%
Чулуун, хүрэн нүүрс олборлолт	280.6	1,194.6	168.7	2,131.6	1,899.6	937.0	78.4%
Газрын түүхий тос, байгалийн хий олборлолт	34.1	128.3	68.5	514.5	514.5	386.2	4.0'
Металлын хүдэр олборлолт	885.5	4,215.6	1,339.9	7,144.1	5,751.3	2,928.5	69.5%
Бусад ашигт малтмал олборлолт	25.9	135.8	40.5	240.4	150.4	104.6	77.1%
Уул уурхайн туслах үйл ажиллагаа	18.7	166.2	5.9	31.7		-134.5	-80.9%
Боловсруулах үйлдвэр	394.0	2,557.8	380.5	3,134.9	766.9	577.1	22.6%
Үүнээс, хүнд үйлдвэр	149.1	936.4	96.1	940.6	507.9	4.2	0.4%
Кокс, газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	69.9	460.7	4.5	292.4	236.6	-168.3	-36.5%
Химийн бодис, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	9.0	51.6	4.5	66.8		15.2	29.4%
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	39.3	159.3	52.5	216.5		57.2	35.9%
Металл боловсруулах үйлдвэрлэл	30.3	260.2	33.5	359.3	271.2	99.1	38.1%
Машин, ТТ-өөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.3	2.2	0.8	3.8	0.2	1.6	74.0%
Тээврийн хэрэгслийн бусад тоног төхөөрөмж үйлдвэрлэл	0.3	2.4	0.2	1.9		-0.6	-23.0%

Эх сурвалж: ҮСХ

Тайлбар: 1 – дахин их

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2021 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр 14.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.9 (53.2%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 10.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.2 (72.3%) их наяд төгрөгөөр өсөхөд металлын хүдэр олборлолтын салбарын борлуулалт 2.9 (69.5%) их наяд төгрөг, чулуун, хүрэн нүүрс олборлолтын салбарын борлуулалт 937.0 (78.4%) тэрбум төгрөг, газрын тосны олборлолтын салбарын борлуулалт 386.2 (4.0 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлөв.

Харин уул уурхайн туслах үйл ажиллагааны салбарын борлуулалт 134.5 (80.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан нийт бүтээгдэхүүнээс 9.1 их наяд төгрөг буюу 64.5 хувийг гадаад зах зээлд борлуулсан байна. Гадаад зах зээлд борлуулсан нийт бүтээгдэхүүний 8.3 их наяд төгрөг буюу буюу 91.6 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн эзэлж байна.

## 2.4. АЖҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ АЖИЛЛАГСАД

хүнээр

Салбар	2018	2019	2020	2021*	Өөрчлөлт			
	I-VII				(5-3)=?, (5/3)=%		(5-4)=?, (5/4)=%	
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	72,372	77,227	75,507	78,318	1,091	1.4%	2,811	3.7%
Уул уурхай, олборлолт	23,707	24,626	24,338	24,797	171	0.7%	459	1.9%
Чулуун, хүрэн нүүрс олборлолт	7,487	7,570	7,355	7,651	81	1.1%	296	4.0%
Газрын түүхий тос, байгалийн хий олборлолт	1,585	1,547	1,398	1,398	-149	-9.6%	-	0.0%
Металлын хүдэр олборлолт	12,859	13,750	13,463	12,231	-1,519	-11.0%	-1,232	-9.2%
Бусад ашигт малтмал олборлолт	1,776	1,641	1,913	3,263	1,622	98.8%	1,350	70.6%
Уул уурхайн туслах үйл ажиллагаа		118	209	254	136	2.1'	45	21.5%
Боловсруулах үйлдвэр	30,184	33,252	31,397	33,186	-66	-0.2%	1,789	5.7%
Үүнээс, хүнд үйлдвэр	6,283	7,002	6,269	6,227	-775	-11.1%	-42	-0.7%
Кокс болон газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	188	673	209	188	-485	-72.1%	-21	-10.0%
Химийн бодис, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	529	873	948	953	80	9.2%	5	0.5%
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	3,597	3,423	3,232	3,248	-175	-5.1%	16	0.5%
Металл боловсруулах үйлдвэрлэл	1,716	1,778	1,668	1,487	-291	-16.4%	-181	-10.9%
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	154	159	112	251	92	57.9%	139	124.1%
Тээврийн хэрэгслийн бусад тоног төхөөрөмж үйлдвэрлэл	99	96	100	100	4	4.2%	-	0.0%

Эх сурвалж: YCX

Тайлбар: 1 - дахин их

### 3. ГАДААД ХУДАЛДАА

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2021 оны эхний 7 сарын байдлаар 8,579.8 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 1,849.1 сая ам.доллар буюу 27.5 хувиар өссөн байна. Экспорт импортоос давамгайлж 903.4 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй гарсан байна.

#### 3.1. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ

Нийт экспорт 2021 оны эхний 7 сарын байдлаар 4,741.6 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 953.0 сая ам.доллар буюу 25.2 хувиар өссөн байна.

Үүнээс: Эрдэс бүтээгдэхүүний экспорт 4,274.3 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 693.9 сая ам.доллар буюу 19.4 хувиар өссөн байна.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, хайлуур жонш, молибдены баяжмал, боловсруулаагүй нефть, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт, мөнгө, тунгаасан зэс ба хайлш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь нийт экспортын 90.1 хувийг эзэлж байна.

#### Эрдэс бүтээгдэхүүний экспортын дундаж үнэ

Барааны нэр	Хэмжих нэгж	2020	2021	Өөрчлөлт	
		I-VII		Өсөлт/бууралт	Хувь
Чулуун нүүрс	тн/ам.дол	78.5	110.8	32.3	41.2%
Зэсийн баяжмал	тн/ам.дол	1,102.3	2,191.6	1,089.2	98.8%
Түүхий нефть болон газрын тос	бар/ам.дол	35.9	60.0	24.2	67.4%
Төмрийн хүдэр, баяжмал	тн/ам.дол	70.4	141.3	70.9	100.7%
Цайрын хүдэр, баяжмал	тн/ам.дол	1,192.9	1,519.1	326.2	27.3%
Хайлуур жоншны хүдэр, баяжмал	тн/ам.дол	237.7	215.7	-21.9	-9.2%
Молибдены хүдэр, баяжмал	тн/ам.дол	6,739.9	8,604.8	1,864.9	27.7%
Алт	кг/ам.дол	57,116.4	59,629.5	2,513.1	4.4%

Эх сурвалж: ГЕГ

#### 3.1.1. Уул уурхай, олборлох салбар

**Чулуун нүүрсний экспорт:** 2021 оны эхний 7 сарын байдлаар 1,100.8 сая ам.долларын 9.9 сая тн чулуун нүүрс экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 221.3 сая ам.доллар буюу 25.2 хувиар өссөн ч, биет хэмжээгээр 1,272.6 мян.тн буюу 11.4 хувиар буурсан байна. 1 тн чулуун нүүрсний экспортын дундаж үнэ 110.8 ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 32.3 ам.доллар буюу 41.2 хувиар өссөн байна. Чулуун нүүрсний 95.0 хувийг БНХАУ, 4.3 хувийг Сингапур Улс руу тус тус экспортолсон байна.

**Зэсийн баяжмалын экспорт:** 2021 оны эхний 7 сарын байдлаар 1,638.2 сая ам.долларын 747.5 мян.тн зэсийн баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 762.6 сая ам.доллар буюу

87.1 хувиар өссөн ч, биет хэмжээгээр 46.8 мян.тн буюу 5.9 хувиар буурсан байна. 1 тн зэсийн баяжмалын экспортын дундаж үнэ 2,191.6 ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 1,089.2 ам.доллар буюу 98.8 хувиар өссөн байна. Зэсийн баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Төмрийн хүдэр, баяжмалын экспорт: 2021 оны эхний 7 сарын байдлаар 665.2 сая ам.долларын 4,708.0 мян.тн төмрийн хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 319.9 сая ам.доллар буюу 92.6 хувиар өссөн ч, биет хэмжээгээр 196.0 мян.тн буюу 4.0 хувиар буурсан байна. 1 тн төмрийн хүдэр, баяжмалын экспортын дундаж үнэ 141.3 ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 70.9 ам.доллар буюу 2.0 дахин өссөн байна. Төмрийн хүдэр, баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Хайлуур жоншны хүдэр, баяжмалын экспорт: 2021 оны эхний 7 сарын байдлаар 98.8 сая ам.долларын 458.2 мян.тн хайлуур жоншны хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 87.8 мян.тн буюу 23.7 хувиар, үнийн дүнгээр 10.8 сая ам.доллар буюу 12.3 хувиар тус тус өссөн байна. 1 тн хайлуур жоншны экспортын дундаж үнэ 215.7 ам.доллар болж, 21.9 ам.доллар буюу 9.2 хувиар буурсан байна. Хайлуур жоншны 78.2 хувийг БНХАУ, 21.8 хувийг ОХУ руу тус тус экспортолсон байна.

Цайрын баяжмалын экспорт: 2021 оны эхний 7 сарын байдлаар 114.3 сая ам.долларын 75.2 мян.тн цайрын баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 2.0 мян.тн буюу 2.6 хувиар буурсан ч, үнийн дүнгээр 22.2 сая ам.доллар буюу 24.1 хувиар өссөн байна. 1 тн цайрын баяжмалын экспортын дундаж үнэ 1,519.1 ам.доллар болж, 326.2 ам.доллар буюу 27.3 хувиар өссөн байна. Цайрын баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Молибдены баяжмалын экспорт: 2021 оны эхний 7 сарын байдлаар 35.1 сая ам.долларын 4,077.7 тн молибдены баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 10.8 сая ам.доллар буюу 44.4 хувиар, биет хэмжээгээр 473.6 тн буюу 13.1 хувиар тус тус өссөн байна. 1 тн молибдены баяжмалын экспортын дундаж үнэ 8,604.8 ам.доллар болж, 1,864.9 ам.доллар буюу 27.7 хувиар өссөн байна. Молибдены баяжмалын 89.8 хувь БНХАУ, 10.2 хувийг БНСУ руу тус тус экспортолсон байна.

Алтны экспорт: 2021 оны эхний 7 сарын байдлаар 218.0 сая ам.долларын 3,656.6 кг алт экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 862.0 сая ам.доллар буюу 79.8 хувиар, биет хэмжээгээр 15,253.4 кг буюу 80.7 хувиар тус тус буурсан байна. 1 кг алтны экспортын дундаж үнэ 59,629.5 ам.доллар болж, 2,513.1 ам.доллар буюу 4.4 хувиар өссөн байна. Алтны 63.8 хувийг Швейцар, 36.2 хувийг БНСУ руу экспортолсон байна.

### 3.1.2. Газрын тосны салбар

Газрын тосны экспорт: 2021 оны эхний 7 сарын байдлаар 196.9 сая ам.долларын 3,281.0 мян.бар газрын тос экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 1,999.1 мян.бар буюу 2.6 дахин, үнийн дүнгээр 151.0 сая ам.доллар буюу 4.3 дахин тус тус өссөн байна. 1 бар газрын тосны экспортын дундаж үнэ 60.0 ам.доллар болж, 24.2 ам.доллар буюу 67.4 хувиар өссөн байна. Газрын тосыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

### 3.1.3. Хүнд үйлдвэрийн салбар

**Коксын экспорт:** 2021 оны эхний 7 сарын байдлаар 8.4 сая ам.долларын 32.3 мян.тн кокс экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 8.2 сая ам.доллар буюу 40.9 дахин, биет хэмжээгээр 31.0 мян.тн буюу 25.3 дахин тус тус өссөн байна.

**Катодын зэс:** 2021 оны эхний 7 сарын байдлаар 55.4 сая ам.долларын 6,284.8 тн катодын зэс экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 400.7 тн буюу 6.8 хувиар, үнийн дүнгээр 23.8 сая ам.доллар буюу 75.0 хувиар тус тус өссөн байна. 1 тн катодын зэсийн экспортын дундаж үнэ 8,818.8 ам.доллар болж, 3,435.8 ам.доллар буюу 63.8 хувиар өссөн байна.

### 3.2. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ

Нийт импорт 2021 оны эхний 7 сарын байдлаар 3,838.2 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 896.1 сая ам.доллар буюу 30.5 хувиар өссөн байна.

Үүнээс, Эрдэс бүтээгдэхүүний импорт 676.4 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 110.9 сая ам.доллар буюу 19.6 хувиар өссөн байна.

#### Эрдэс бүтээгдэхүүний импортын дундаж үнэ

Барааны нэр	Хэмжих нэгж	2020	2021	Өөрчлөлт	
		I-VII		Өсөлт/бууралт	Хувь
Автобензин	тн/ам.дол	419.3	585.5	166.2	39.6%
Дизель түлш	тн/ам.дол	431.2	534.0	102.8	23.8%

Эх сурвалж: ГЕГ

### 3.2.1. Газрын тосны салбар

Эрдэс бүтээгдэхүүний импортын үнийн дүнгийн 83.9 хувийг газрын тосны бүтээгдэхүүн эзэлж байна.

2021 оны эхний 7 сарын байдлаар 567.2 сая ам.долларын 1,003.0 мян.тн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 16.4 мян.тн буюу 1.6 хувиар буурсан ч, үнийн дүнгээр 111.7 сая ам.доллар буюу 24.5 хувиар өссөн байна.

Газрын тосны бүтээгдэхүүний импортын нийт үнийн дүнгийн 82.9 хувийг автобензин, дизель түлшний импорт, үүний 26.9 хувийг автобензин, 56.0 хувийг дизель түлшний импорт тус тус эзэлж байна.

**Автобензины импорт:** 2021 оны эхний 7 сарын байдлаар 152.6 сая ам.долларын 260.5 мян.тн автобензин импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 61.7 мян.тн буюу 19.2 хувиар буурсан ч, үнийн дүнгээр 17.4 сая ам.доллар буюу 12.9 хувиар өссөн байна. 1 тн автобензины импортын дундаж үнэ 585.5 ам.доллар болж, 166.2 ам.доллар буюу 39.6 хувиар өссөн байна.



Дизель түлшний импорт: 2021 оны эхний 7 сарын байдлаар 317.7 сая ам.долларын 595.0 мян.тн дизелийн түлш импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 83.0 сая ам.доллар буюу 35.3 хувиар, биет хэмжээгээр 50.6 мян.тн буюу 9.3 хувиар тус тус өссөн байна. 1 тн дизель түлшний импортын дундаж үнэ 534.0 ам.доллар болж, 102.8 ам.доллар буюу 23.8 хувиар өссөн байна.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ